

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд:

“XXII.8. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх хүрээнд Монголын талаас оруулах 125 сая ам.доллараар тус нийгэмлэгийн суурь бүтцийн дохиолол холбооны байгууламжийг шинэчлэх, автомат хориглол нэвтрүүлэх чиглэлээр хийсэн судалгааны талаар Зам, тээврийн сайд А.Гансүх танилцуулав. Үүнтэй холбогдуулан суурь бүтцийн дохиолол холбооны байгууламжийг шинэчлэх, автомат хориглолын систем нэвтрүүлэх асуудлыг Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Ерөнхий хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Ерөнхий хувь нийлүүлэгч, Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР